



# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

2024 он





**“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН МАТЕРИАЛ**

УЛААНБААТАР ХОТ  
2024.04.29

/“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн хурлын танхим  
“Монгол шуудан” ХК-ийн 4 давхарт/

## ХУРЛЫН МАТЕРИАЛЫН АГУУЛГА

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол ..... 01-07
- “Монгол шуудан” ХК-ийн 2022 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт .....08
- “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны тайлан ..... 09-13
- Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын санал дүгнэлт ..... 14-20
- 2022 оны ногдол ашиг тараасан тайлан болон 2023 оны ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол ..... 21-22
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл 23-40



## “МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 23/04

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.2, 60.4, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 62.1.14, 62.1.14, 62.1.15 дахь заалт, 64 дүгээр зүйлийн 64.2, 64.4, 65 дугаар зүйлийн 65.3, 65.4 дэх заалт, 67 дугаар зүйл, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 10:00 цагт “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн хурлын танхимд зарлан хуралдуулсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй:
  - Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
    - Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах,
    - Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах,
    - Компанийн 2022 оны ногдол ашиг тараасан тухай тайлан болон 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах,
    - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны тайлан танилцуулах,
  - “Монгол шуудан” ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай,
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсөв батлах тухай,
- “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл”-ийг 1 дүгээр хавсралтаар баталж, 2024 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар”-ыг 2 дугаар хавсралтаар баталж 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллага, өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонингоор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, мөн 2024 оны 04 дүгээр сарын 08-ний өдөр анх мэдээлсний дагуу хурлын зарыг дахин хүргэхээр тогтсугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2024 оны 03 дугаар сарын 27-ны дотор багтаан хувьцаа эзэмшигчидтэй харилцаж буй брокер диллерийн компанид хүргүүлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Д.Балжинням, нарийн бичгээр Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Цэцгээг тус тус томилсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар "Монгол шуудан" ХК-ийн Улс хоорондын шуудангийн газрын ахлах мэргэжилтэн О.Сарангэрэл, гишүүдэд "Монгол шуудан" ХК-ийн Мэдээллийн технологийн газрын ахлах мэргэжилтэн Ж.Даваасүрэн, "Ард Секюритиз ҮЦК" ХХК-ийн дэд захирал Г.Долгорсүрэн (зөвшилцсөнөөр) нарыг тус тус томилсугай.
8. Компанийн шуудангийн хаягаар болон брокер диллерийн компаниар дамжуулан урьдчилан санал авах сүүлчийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөр тогтоож, саналын хуудасны агуулга, загварыг 3 дугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 4 дүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт болон тэдгээрийн бэлэн болгох эцсийн хугацааг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар "Монгол шуудан" ХК-ийн Захиргаа, хүний нөөцийн газрын дарга Б.Цэнд-Аюуш, гишүүдэд хүний нөөцийн мэргэжилтэн Э.Солонго, дотоод ажлын мэргэжилтэн Б.Саруул, Мэдээллийн технологийн газрын инженер Б.Дамдинсүрэн нарыг тус тус томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдон гарах зардлыг "Монгол шуудан" хувьцаат компаниас санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захиралд зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



О.САРАНГЭРЭЛ



2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн  
23/04 дугаар нэгтгэлийн 1 дүгээр хавсралт

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“Монгол шуудан” ХК
Хаяг, утас:	Сүхбаатарын талбай-1 Чингэлтэй дүүргийн 1-р хороо Улаанбаатар 15160
Хурал хуралдах өдөр, цаг:	2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр 10:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн хурлын танхимд /Төв шуудангийн баруун хаалга, “Монгол шуудан” ХК-ийн 4 давхарт/
Хурлын төрөл:	Ээлжит хурал
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2024 оны 03 дугаар сарын 18-ны өдөр
Олон нийтэд зарласан огноо:	2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр
Бүртгэлийн өдөр:	2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр
Хүргүүлсэн огноо:	2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр
Хурлын даргын нэр:	Д.Балжинням
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	О.Сарангэрэл, Ж.Даваасүрэн, Г.Долгорсүрэн
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	- “Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал - Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан - Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт
Баримт бичгийн хуудасны тоо:	..... ширхэг
	..... хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

..... /Б.Цэнд-Аюуш/

2024 оны 03 дугаар сарын 18-ны өдөр



2024 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн  
23/04 дугаар тэмдэглэл 2 дугаар хавсралт

## **“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР**

### **Компанийн оноосон нэр:**

“Монгол шуудан” ХК, Сүхбаатарын талбай 1,  
Энхтайвны өргөн чөлөө, ЧД 1 дүгээр хороо, Улаанбаатар 15160

### **Хурал хуралдуулах газар, өдөр, цаг:**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 10:00 цагт “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн хурлын танхимд /Төв шуудангийн баруун хаалга, “Монгол шуудан” ХК-ийн 4 давхарт/

### **Хуралд оролцох эрхтэй ХЭ-чдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:**

2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр

### **Хурлаар хэлэлцэх асуудал:**

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
  - ✓ Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах,
  - ✓ Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах,
  - ✓ Компанийн 2022 оны ногдол ашиг тараасан тухай тайлан болон 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах,
  - ✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны тайлан танилцуулах,
- “Монгол шуудан” ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай,
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсөв батлах тухай,

### **Холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:**

- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас ([www.mse.mn/mn/company/541](http://www.mse.mn/mn/company/541)), компанийн цахим хуудас ([www.mongolpost.mn](http://www.mongolpost.mn)) дахь “Хувьцаа эзэмшигч” цэсээс электрон хэлбэрээр болон ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд өөрийн харилцаж буй брокер дилерийн компани болон компанийн төв байранд ирж авч болно.
- Хувьцаа эзэмшигч та саналаа урьдчилан өгөх боломжтой бөгөөд өөрийн үйлчлүүлдэг Үнэт цаасны компаниар дамжуулж компанид ирүүлж болно. Мөн компанийн цахим хуудас ([www.mongolpost.mn](http://www.mongolpost.mn)) дахь “Хувьцаа эзэмшигч” цэсэд байрлах саналын хуудсыг татан авч саналаа бөглөн дараах хаягаар битүүмжлэн ирүүлж болно. Саналын хуудсаар санал авах сүүлийн хугацаа 2024 оны 04 сарын 24-ний өдрийн 17:00 цаг байна.

Хаяг: Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисст  
“Монгол шуудан” ХК, Сүхбаатарын талбай-1,  
ЧД-ийн 1-р хороо, Улаанбаатар 15160

### **Холбоо барих:**

Хурал зохион байгуулах комисс: Б.Цэнд-Аюуш, Э.Солонго, Утас: 70078906

[tsend-ayush@mongolpost.mn](mailto:tsend-ayush@mongolpost.mn), [tsetsgee@mongolpost.mn](mailto:tsetsgee@mongolpost.mn)

**Хурлын ирцийн бүртгэл 2024 оны 04 сарын 29-ны өдрийн 09:30-10:00 цагийн хооронд явагдана.**





2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн  
23/04 дугаар тогтоолын 3 дугаар хэсэрт

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

/ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ-1, 2, 3/

Компанийн оноосон нэр: **“Монгол шуудан” ХК**

Хурал хуралдах газар, өдөр: **“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн хурлын танхим**  
/Төв шуудангийн баруун хаалга, 4 давхарт/  
**2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр 10:00 цагт**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:	
Хувьцаа эзэмшигчийн утасны дугаар:	
Хувьцаа эзэмшигчдийн мэйл хаяг:	
Регистрийн дугаар:	
Эзэмшиж буй хувьцааны тоо:	

Санал хураах арга: **Энгийн**

№	Хэлэлцэх асуудал	Шийдвэр	Хувьцаа эзэмшигчийн санал		
			Зөвшөөрсөн	Татгалзсан	Түтгэлцсэн
1	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах	ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай			
2	“Монгол шуудан” ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай			
3	ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийг батлах тухай	Зардлын төсөв батлах тухай			

Заавар: Та өөрийн саналыг ( “✓” “болон “+” ) тэмдгээр тэмдэглэнэ.

Хувьцаа эзэмшигч хувь хүний бөглөх хэсэг	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн бөглөх хэсэг
Овог нэр: .....	Хуулийн этгээдийн нэр: .....
Гарын үсэг: .....	Улсын бүртгэлийн дугаар: .....
Хувьцаа эзэмшигч хувь хүн болон хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бөглөх хэсэг	
Нэр: .....	Албан тушаал: .....
Гарын үсэг: .....	
Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг: .....	
Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг: .....	

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): **Тийм** **Үгүй**

Комиссын дарга: .....

Гишүүд: .....

.....

Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл: .....



МОНГОЛ ШУУДАН ХК-ийн ТУЗ-ийн  
2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн  
23/04 дугаар тогтоолыг 4 дугаар хэвсрэлт

**"МОНГОЛ ШУУДАН" ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

"Монгол шуудан" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 10:00 цагт "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн хурлын танхимд болно.  
/Төв шуудангийн баруун хаалга, "Монгол шуудан" ХК-ийн 4 давхарт/

№	Үйл ажиллагаа	Шийдвэр	Хугацаа	Хариуцаах эзэн
1	Бүртгэлийн үйл ажиллагаа - Хурлын ирцийг бүртгэх, мэдээлэх	Тогтоол	09:30-10:00	Тооллогын комисс
2	Хурлын нээлт - Хурлыг нээх, хурлын дэг танилцуулах		10:00-10:10	Хурлын дарга
3	Хэлэлцэх асуудал-1: Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах; - Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах, - Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Аудитын хорооны дүгнэлтийг танилцуулах, - Компанийн 2022 оны ногдол ашиг тараасан тухай тайлан, 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах, - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны тайлан, дүгнэлтийг танилцуулах,  Асуулт, хариулт	ХЭХ-Тогтоол	10:10-11:10	Гүйцэтгэх захирал  Аудитын хорооны дарга Д.Балдорж  Хараат бус гишүүн Б.Ганбаатар  ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл
4	Хэлэлцэх асуудал-2: "Монгол шуудан" ХК-ийн дүрэмд орох нэмэлт өөрчлөлтийг батлах; - "Монгол шуудан" ХК-ийн дүрэмд орох нэмэлт өөрчлөлтийг танилцуулах,  Асуулт, хариулт		11:10-11:20	Компанийн хуулийн зөвлөх О.Отгонбаяр
5	Хэлэлцэх асуудал-2: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсөв батлах; - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг танилцуулах,  Асуулт, хариулт		11:20-11:30	Хараат бус гишүүн Ч.Амарбаатар
6	Санал хураалтыг нэгтгэх /Завсарлага/		11:30-11:50	Тооллогын комисс
7	Санал хураалтын дүн болон хурлаас гарах шийдвэрийг танилцуулах	Тогтоол	11:50-11:55	Тооллогын комисс Хурлын дарга
8	Хурал хаах		11:55-12:00	Хурлын дарга

Хурал урьдчилсан байдлаар 2 цаг үргэлжилнэ.



**ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБОГДСОН  
МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ, БЭЛЭН БОЛГОХ ХУГАЦАА**

<b>№</b>	<b>Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох мэдээлэл</b>	<b>Бэлэн болгох хугацаа</b>
1	“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал	2024.03.27
2	Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан	2024.03.27
3	Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт	2024.03.27

## “МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

“Монгол шуудан” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг Компанийн тухай хууль, “Монгол шуудан” ХК-ийн дүрмийн холбогдох заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

Тус компани нь 2023 онд 22,884.0 сая төгрөгийн орлого олж 22,175.9 сая төгрөгийн зардлыг гарган 637.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөн бодит гүйцэтгэлээр 25,397.8 сая төгрөгийн орлого олж, 23,289.9 сая төгрөгийн зардал гарган 1,967.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Компани нь 2023 оны нийт борлуулалтын төлөвлөгөөгөө 111% буюу 2.5 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.6% буюу 5.0 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Компанийн хувьд 2023 онд дотоод шуудангийн үйл ажиллагааг өргөжүүлэх, орлогыг нэмэгдүүлэх, дотоодын шуудан тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, компанийн үйл ажиллагаанд цахим шилжилтүүдийг нэвтрүүлэх, улс хоорондын болон дотоодын шуудан, тээвэр, хүргэлтийн үндсэн системийг нэвтрүүлэх, цалин, цаг бүртгэл, хүний нөөцийн системийг шинэчлэх, гүйцэтгэлд суурилсан цалин урамшууллын системийг боловсронгуй болгох зэрэг компанийн үйл ажиллагааг урт болон дунд хугацаанд өргөжүүлэх, тогтвортой байдлыг хангах, компанийн үр ашгийг сайжруулахад гол үйл ажиллагааг чиглүүлэн ахиц гарган ажилласан байна. Харин хил дамнасан и-худалдааны бизнес буюу транзит үйлчилгээний орлого болон улс хоорондын шуудангийн бизнесийн орлого хөрш орнуудын нөхцөл байдал, бусад шалтгааны улмаас төлөвлөгөөнд хүрээгүй боловч мөнгөн хөрөнгийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлснээр тус алдагдлыг нөхөж ашигтай ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байна.

Иймд “Монгол шуудан” ХК-ийн 2023 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглаж “Сайн” ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

## “МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн хүрээнд Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, компанийн стратегийн зорилтот түвшин, санхүү эдийн засгийн үзүүлэлт, бизнес төлөвлөгөөг баталж, биелэлтэд улирал тутам хяналт тавьж, холбогдох чиг үүрэг, зөвлөмжүүдийг өгч ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ХЭ-23/03 дугаар тогтоолоор ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 2 жилийн хугацаатай шинэчлэгдэн томилогдсон.

Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Аудитын, Засаглал нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон Стратеги, эрсдэлийн удирдлагын хороог ажиллуулж, засаглалын болон дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан.

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

Төлөөлөн удирдах зөвлөл нь 67-100 хувийн ирцтэйгээр 9 удаагийн хуралдаан /эчнээ, танхим/-аар доорх 28 асуудлуудыг хэлэлцэж, 17 тогтоол, 9 тэмдэглэлээр шийдвэр гарган, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна. Үүнд:

Огноо	Дугаар	Шийдвэрийн агуулга
2023.04.24	23/04	Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх тухай Ялган боловсруулах төвийн барилга угсралтын ажилд нэмэлт санхүүжилт олгох тухай
	23/05	ТУЗ-ийн даргыг сонгох тухай
2023.07.06	23/06	ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай
	23/09	Ялган боловсруулах төвийн барилга угсралтын ажилд нэмэлт санхүүжилт олгох тухай
	23/10	хорооны дүгнэлтийг хэлэлцэх тухай
	23/11	Беларус улсын шуудангийн байгууллагатай хоёр талт хамтын ажиллагааны гэрээ байгуулах тухай
	23/12	Үндсэн хөрөнгө актлах тухай

	04	Гүйцэтгэх захирлын цалингийн хэмжээг нэмэгдүүлэх тухай
2023.08.25	05	Компанийн 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцах тухай
	23/13	Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэх тухай
2023.12.20	23/14	Компанийн засаглалын кодексын хэрэгжилттэй холбоотойгоор холбогдох бодлогын баримт бичиг, журам батлах тухай
	06	Компанийн 2024 оны зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлах тухай
2024.02.16	01	Стратеги, эрсдэлийн удирдлагын хорооны дүгнэлт танилцуулах тухай
	24/01	Компанийн менежментийн үйл ажиллагаанд үнэлэлт өгч, санал дүгнэлт гаргах тухай
2024.02.26	24/02	Компанийн 2023 оны санхүү эдийн засаг, үйл ажиллагааны тайлан хэлэлцэх тухай
	02	Ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэр гаргах тухай
2024.03.18	24/03	ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай
	24/04	Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны хурлын дүгнэлт /Сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлт танилцуулах тухай/
2024.03.21	03	Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт хэлэлцэх тухай
	04	Компанийн 2024 оны төлөвлөгөөнд тодотгол оруулах тухай
2024.03.26	03	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай
	24/05	ТУЗ-ийн 2023 оны тайлан танилцуулах тухай
2024.03.26	04	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх тухай
	05	Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэж танилцуулах тухай
2024.03.26	24/06	Гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтын дүн танилцуулах тухай
	24/07	Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх тухай
	24/08	Гүйцэтгэх захирлыг чөлөөлөх тухай
	24/08	Гүйцэтгэх захирлыг томилох тухай

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Аудитын хороо, Засаглал нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Стратеги,

эрсдэлийн удирдлагын хороог ажиллуулж, засаглалын болон дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан.

#### Стратеги эрсдэлийн удирдлагын хороо:

Тус хороо нь компанийн стратеги төлөвлөгөө болон тухайн жилийн бизнес төлөвлөгөө, түүний биелэлтийг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгөх, компанийн үйл ажиллагаа, санхүү, хууль эрх зүйн эрсдэлийг тодорхойлох, бууруулах, урьдчилан сэргийлэх талаарх бодлогыг тодорхойлох, компанийн үнэ цэнийг өсгөх, үйл ажиллагааг сайжруулах талаар санал боловсруулах зэрэг чиг үүргүүдийг хэрэгжүүлж ажилласан.

Хорооны дарга: ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Батцэцэг  
Гишүүд: ТУЗ-ийн ердийн гишүүн О.Одбаяр  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Балдорж  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Ганбаатар  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Амарбаатар

Тайлант хугацаанд 3 удаа хуралдаж доорх асуудлуудыг хэлэлцэж, хорооны чиг үүргийнхээ хүрээнд гүйцэтгэх удирдлагад зөвлөмж, чиглэл өгч, дүгнэлт гарган Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, биелэлтэд хяналт тавин ажилласан.

- Ялган боловсруулах төвийн барилга угсралтын ажилд нэмэлт санхүүжилт олгох тухай
- Беларус улсын шуудангийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах тухай
- Компанийн 2024 оны зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө хэлэлцэх тухай

#### Аудитын хороо:

Тус хороо нь компанийн нягтлан болох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцэж буй эсэхэд хяналт тавих, хараат бус аудитын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг чиг үүргүүдийг хэрэгжүүлж ажилласан.

Хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Балдорж,  
Гишүүд: ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Дэлгэрмаа

ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Балдорж,  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Ганбаатар  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Амарбаатар

Тайлант хугацаанд 3 удаа хуралдаж доорх асуудлуудыг хэлэлцэж, хорооны чиг үүргийнхээ хүрээнд нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдалд хяналт тавьж, удирдлагуудад санал зөвлөмж, үүрэг даалгавар өгч ажиллав. Мөн 2 удаагийн хуралдааныг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу Стратеги, эрсдэлийн удирдлагын хороотой хамтран хийсэн болно. Үүнд:

- Дотоод аудитын хэлтсийн 2022 оны тайлантай танилцах тухай
- Компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт танилцуулах тухай
- Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн үнэлгээний хяналт баталгаажуулалтын тухай
- Ялган боловсруулах төвийн барилга угсралтын ажилд нэмэлт санхүүжилт олгох тухай

#### Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо:

Тус хороо нь компанийн ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх, шалгуурыг тогтоох, ТУЗ-д нэр дэвшигчдийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, ХЭ-чдийн хуралд нэр дэвшүүлэх, гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах, үнэлэх, дүгнэлт гаргах, ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын хэмжээг тогтоох, санал боловсруулах зэрэг чиг үүргүүдийг хэрэгжүүлж ажилласан.

Хорооны дарга: ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Тэлмэн  
Гишүүд: ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Балжинням  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Балдорж,  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Ганбаатар  
ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Амарбаатар

Тайлант хугацаанд 5 удаа хуралдаж доорх асуудлуудыг хэлэлцэн хорооны чиг үүргийнхээ хүрээнд санал зөвлөмж өгч ажилласан байна. Үүнд:



- Компанийн засаглалын кодексын хэрэгжилттэй холбоотой баримт бичиг, дүрэм журмыг хэлэлцэх тухай
- Гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтын жишиг шалгуур үзүүлэлтийг боловсруулах тухай
- Цалин хөлс нэмэгдүүлэх шаардлагын дагуу шийдвэрлэх арга замын талаар санал боловсруулах тухай
- Гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалт явуулах тухай
- ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв хэлэлцэх тухай
- Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх тухай

### Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын тайлан

Тайлант хугацаанд 198,000,000 /нэг зуун ерэн найман сая/ төгрөгийн зардал (2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ХЭ-23/02 дугаар тогтоолоор батлагдсан) төлөвлөж, гүйцэтгэл 172,682,000 (нэг зуун далан хоёр мянга зургаан зуун наян хоёр мянга) төгрөг буюу 87.2%-ийн гүйцэтгэлтэй гарсан байна.

### Төлөөлөн удирдах зөвлөлөөс зохион байгуулсан бүсэд ажил

- Шинэ ялган боловсруулах төвийн нэмэлт санхүүжилттэй холбоотойгоор барилгын явц, гүйцэтгэлтэй газар дээр нь очиж танилцсан.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлээр гарсан шийдвэр батлагдсан хуваарийн дагуу 4 чиглэлд хуваарилагдан Улаанбаатар хот дах ШҮ-ний салбар нэгжүүдтэй танилцах, ажилтнуудтай уулзах, ажлын байрны орчин, ажилтнуудын санал гомдол, тулгамдаж буй асуудлуудтай танилцан, үр дүнг тайлагнан ажилласан.

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/443  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**МОНГОЛ ШУУДАН ХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.АНХБААТАР  
ТАНАА****Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол шуудан ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монгол шуудан ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хөшигтийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал дахь 5,358.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Ялган боловсруулах төв"-ийг 2020 онд эхлүүлж, барилгын ажлыг 2024 оны 1 дүгээр сард ашиглалтад оруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Монгол шуудан ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 22/15 дугаар тогтоолоор компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг баталж, нийт орлогыг 22,884.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 22,175.9 сая төгрөгөөр, 708.1 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,518.8 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 25,397.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 23,289.9 сая төгрөгийг зарцуулж, 2,107.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Компанийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндсэн чиглэлийн 9 зорилтын хүрээнд 176 арга хэмжээний ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 80.3 хувийн

Z:\Yawsan\_Bichgi\2024\0315\_SNAG-17.Docx

0001051364

гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



## Монгол шуудан ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	19,385,981,879.08	16,148,550,148.05
1.1.2	Дансны авлага	5,886,568,927.89	2,667,175,998.76
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	41,101,472.25	135,689,028.00
1.1.4	Бусад авлага	332,984,445.92	143,565,228.09
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	157,769,001.00	-
1.1.6	Бараа материал	3,479,935,861.85	3,498,586,855.77
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,713,694,026.89	4,978,395,671.53
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>32,998,035,614.88</b>	<b>27,571,962,930.20</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	8,471,048,949.22	8,495,852,792.93
1.2.2	Биет бус хөрөнгө	2,041,828,165.60	2,308,742,471.37
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	500,000.00	500,000.00
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>10,513,377,114.82</b>	<b>10,805,095,264.30</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>43,511,412,729.70</b>	<b>38,377,058,194.50</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	17,778,450,709.99	10,459,357,649.33
2.1.1.2	Цалингийн өглөг	-	230,582,579.90
2.1.1.3	Татварын өр	168,138,133.12	134,928,454.27
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	14,161,569.68
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	339,069,766.99	917,222,935.68
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	234,143,968.36	473,428,527.19
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>18,519,802,578.46</b>	<b>12,229,681,716.05</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>18,519,802,578.46</b>	<b>12,229,681,716.05</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч-терийн	6,572,700,000.00	6,572,700,000.00
2.3.2	-хувийн	3,385,936,300.00	3,385,936,300.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	2,538,512,210.45	2,538,512,210.45
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,379,919,523.85	3,379,919,523.85
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	4,300,458,597.23	3,714,085,782.53
2.3.9	Хуримтлагдсан ашиг	4,814,083,519.71	6,556,222,661.62
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>24,991,610,151.24</b>	<b>26,147,376,478.45</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>43,511,412,729.70</b>	<b>38,377,058,194.50</b>

## Монгол шуудан ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	18,491,088,870.70	19,369,578,379.77
2	Борлуулалтын өртөг	18,464,332,021.74	21,526,001,245.47
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>26,756,848.96</b>	<b>(2,156,422,865.70)</b>
4	Түрээсийн орлого	115,241,194.05	137,959,815.10
5	Хүүгийн орлого	584,082,910.22	460,898,494.38
6	Бусад орлого	-	-
7	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
8	Ерөнхий ба удирдлагын зардал	1,147,771,767.30	1,525,406,320.67
9	Санхүүгийн зардал	-	-
10	Бусад зардал	170,052,835.67	238,476,875.16
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	1,201,078,732.14	5,393,800,778.03
12	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	35,498,459.38
13	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>609,335,082.40</b>	<b>2,107,851,485.36</b>
14	Орлогын татварын зардал	158,051,990.96	140,136,455.05
15	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>451,283,091.44</b>	<b>1,967,715,030.31</b>
16	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	451,283,091.44	1,967,715,030.31
17	Орлогын нийт дүн		
18	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдалтай)</b>	<b>451,283,091.44</b>	<b>1,967,715,030.31</b>

Монгол шуудан ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний дугаар болсон

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	6,572,700,000.00		3,379,919,523.85	4,300,458,597.23	4,602,511,381.17	18,855,589,502.25
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					451,283,091.44	451,283,091.44
Өмчид гарсан өөрчлөлт	3,385,936,300.00	2,538,512,210.45			(239,710,952.90)	5,684,737,557.55
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	4,300,458,597.23	4,814,083,519.71	24,991,610,151.24
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					1,967,715,030.31	1,967,715,030.31
Өмчид гарсан өөрчлөлт				(586,372,814.70)		(586,372,814.70)
Зарласан ногдол ашиг					(225,575,888.40)	(225,575,888.40)
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	3,714,085,782.53	6,556,222,661.62	26,147,376,478.45

## Монгол шуудан ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	125,884,989,790.76	103,925,063,975.29
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	14,849,382,704.84	15,540,296,005.08
	Бусад мөнгөн орлого	111,052,607,085.92	88,384,767,970.21
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	121,450,100,365.99	106,430,984,826.27
	Ажиллагчдад төлсөн	7,244,776,405.17	8,075,806,596.46
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,266,214,006.36	2,483,989,133.86
	Бараа материал худалдан авахад төлсөн	2,949,629,551.54	2,278,190,902.30
	Ашиглалтын зардалд төлсөн	1,819,030,861.01	1,882,203,696.27
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,240,415,086.86	3,605,436,850.60
	Татварын байгууллагад төлсөн	1,334,722,721.46	1,511,026,301.00
	Даатгалын төлбөрт төлсөн	116,694,757.20	122,993,711.52
	Бусад мөнгөн зарлага	102,478,616,976.39	86,471,337,634.26
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>4,434,889,424.77</b>	<b>(2,505,920,850.98)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	357,082,910.22	650,725,627.87
	Хүлээн авсан хүүний орлого	357,082,910.22	650,725,627.87
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,777,149,476.43	2,168,349,927.20
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,343,924,826.43	2,079,908,727.20
	Биет бус хөрөнгө хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	283,224,650.00	88,441,200.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	150,000,000.00	-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,420,066,566.21)</b>	<b>(1,517,624,299.33)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	192,939,819.90	221,219,675.23
	Төлсөн ногдол ашиг	192,939,819.90	221,219,675.23
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(192,939,819.90)	(221,219,675.23)
	Валютын ханшийн зөрүү	2,243,086,566.08	1,007,333,094.51
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>5,081,969,604.74</b>	<b>(3,237,431,731.03)</b>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,304,012,274.34	19,385,981,879.08
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,385,981,879.08	16,148,550,148.05

## Монгол шуудан ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

2023 оны 12 дугаар сарын 31-ний дуусаар болсон

/сая.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
			1	2	3	4=2-3	5
1.	Нийт орлого	сая.төг	20,391.5	22,884.0	25,397.7	(2,513.7)	111.0
2.	Нийт зардал	сая.төг	19,782.2	22,175.9	23,289.9	(1,114.0)	105.0
3.	Татварын өмнөх ашиг	сая.төг	609.3	708.1	2,107.8	(1,399.9)	297.7
4.	Орлогын татварын зардал	сая.төг	158.1	70.8	140.1	(69.3)	197.9
5.	Цэвэр ашиг	сая.төг	451.3	637.3	1,967.8	(1,330.5)	308.8
6.	Нийт ажиллагсад	хүн	959	1000	956	44	95.6
7.	Цалингийн сан	сая.төг	9,184.4	10,704.4	10,114.7	589.7	94.5
8.	Нийт авлага	сая.төг	6,260.7	3,000.0	2,946.4	53.6	98.2
9.	Нийт өр төлбөр	сая.төг	18,519.8	12,500.0	12,229.7	270.3	97.8
10.	Нийт хөрөнгө оруулалт	сая.төг	1,336.4	2,518.8	975.8	1,543.0	38.7
11.	Ногодол ашиг	сая.төг	225.6	318.6	597.2	(278.6)	187.4
12.	Элэгдлийн зардал	сая.төг	1,011.8	1,280.0	1,170.2	109.8	91.4



## 2022 ОНЫ НОГДОЛ АШИГ ТАРААЛТЫН ТАЙЛАН

2022 оны ногдол ашгийг 2023 оны 12 дугаар сарын 18-ний өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх замаар 100% олгосон.

Нийт хувьцааны тоо	99,586,363		<b>НИЙТ</b>
Нийт зарласан ногдол ашгийн дүн /төг/	225,641,500.00		
Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг /төг/	2.26		
Ногдол ашиг олгосон хэлбэр	ҮЦТХТ ХХК-иар зуучлуулан		
Ногдол ашиг тараасан огноо	2023.12.18	2023.12.18	
Олгосон ногдол ашиг /төг/	76,718,110.00	148,923,390.00	<b>225,641,500.00</b>
Олгосон ногдол ашиг /хувь/	34%	66%	<b>100%</b>
Хувьцааны тоо	33,859,363	65,727,000	<b>99,586,363</b>
Хувьцаа эзэмшигчдийн тоо	3253	1	<b>3254</b>



## “МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 2А/01

Улаанбаатар хот

### Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 4.16 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 4.3 дахь заалт, Улсын их хурлын 2021 оны 88 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 675 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” ХК-ийн 2023 оны цэвэр ашгийн дүнгээс 30.36 хувиар тооцож, нийт 597,518,178.00 (таван зуун ерэн долоон сая таван зуун арван найман мянга нэг зуун далан найм) төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахыг зөвшөөрсүгэй.

2. Нэгж хувьцаанд 6.0 (зургаа) төгрөгийн ногдол ашиг тараахыг Гүйцэтгэх захирал /Б.Анхбаатар/-д үүрэг болгосугай.

3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

4. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан тарааж эхэлсүгэй.

5. Энэхүү ногдол ашиг хуваарилалтын шийдвэр болон 2022 оны ногдол ашиг тараасан талаарх тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо /Д.Балдорж/-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ



**“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар \_\_\_\_

Улаанбаатар хот

*Төсөл*

Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.11.9 дэх заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх “Сайн” гэж дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.БАЛЖИННЯМ



## **“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

**2023 оны 04 сарын 29 өдөр**

**Дугаар \_\_\_**

**Улаанбаатар хот**

*Төсөл*

Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.11.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.2, 17.3 дахь заалт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн ээлжит бус хурлын 2016/05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол шуудан” хувьцаат компанийн дүрэмд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1.1. Компанийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт заасан Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь дор дурдсан үйл ажиллагаа, тэдгээртэй холбогдон үүсэх бусад ажил, үйлчилгээ байна гэх хэсэгт 2.2.7 дахь заалтаар “Авто машинаар ачаа тээвэрлэх” гэх заалт,

2. Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн ээлжит бус хурлын 2016/05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол шуудан” хувьцаат компанийн дүрэмд доор дурдсан агуулгатай нэмэлт өөрчлөлт оруулсугай.

2.1. Дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсгийг “Компани нь дүрэмд заасан зорилтоо хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаанаас гадна, хуулиар хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээг өөрийн салбар, төлөөлөгчийн газар, охин компаниудаараа дамжуулан гүйцэтгэж болно. Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд компаниас баталсан журмын дагуу үйл ажиллагаа явуулна” гэж,

2.2. Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3.3 дахь хэсгийг “Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан зорилтот түвшинд үндэслэн компанийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, батлах;” гэж,

2.3. Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3.15 дахь хэсгийг “Гадаадад болон Аймаг, Нийслэлийн төвд Компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах” гэж,

2.4. Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.12.2 дахь хэсгийг “өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал

эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй,” гэж,

2.5. Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3.4 дэх хэсгийг “Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, удирдлагын зардлын дээд хязгаарыг батлах” гэж,

2.6. Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.14 дэх хэсгийг “Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудитын, Цалин, урамшууллын, Нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна. Хороодын дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус мөн хараат бус гишүүн байна” гэж,

2.7. Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг “Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд ТУЗ-ийг төлөөлж түүний дарга гарын үсэг зурна. Гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.” гэж,

2.8. Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.10.9 дахь хэсгийг “ТУЗ-өөс баталсан орон тооны дээд хязгаар, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд компанийн ажлын байрны жагсаалт, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох” гэж,

2.9. Дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг “Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, Гүйцэтгэх захирал, дэд захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн /Дүрмийн 9.8 дахь хэсэгт заасан Захирлын зөвлөлийн гишүүдийг ойлгоно/, ерөнхий нягтлан бодогч, Санхүү эрхэлсэн нэгжийн удирдлага, дотоод хяналтын нэгжийн удирдлага, худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн удирдлага, аймаг хариуцсан шуудангийн үйлчилгээний нэгжийн удирдлагыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно” гэж,

2.10. Дүрмийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь хэсгийг “Компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай шийдвэр, ажиллах журам” гэж

3. Энэхүү тогтоолын 1, 2 дахь хэсэгт заасан дүрмийн нэмэлт өөрчлөлтийг тусгасан “Монгол шуудан” хувьцаат компанийн шинэ дүрмийг хавсралтаар баталсугай.

4. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Д.БАЛЖИННЯМ

*“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн  
ээлжит хурлын ..... оны .... сарын .... өдрийн  
..... дугаар тогтоолын хэвсрэлт*

## **“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 Энэхүү дүрэм (цаашид “Дүрэм” гэх) нь “Монгол шуудан” хувьцаат компанийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон эрх зүйн үндсэн баримт бичиг мөн.

1.2. “Монгол шуудан” хувьцаат компани (цаашид “Компани” гэх) нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Шуудангийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан тогтоол шийдвэр, дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.3. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээдэг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, санхүүгийн тайлан гаргадаг, ашгийн төлөө хуулийн этгээд мөн.

1.4. Компанийн 34 хувийг олон нийт, 66 хувийг төр эзэмшинэ. Төрийн эзэмшлийн хувьцааны бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосон этгээд байна.

1.5. Компани нь дүрэмд заасан зорилтоо хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаанаас гадна, хуулиар хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээг өөрийн салбар, төлөөлөгчийн газар, охин компаниудаараа дамжуулан гүйцэтгэж болно. Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд компаниас баталсан журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

1.6. Компанийн оноосон нэр нь Монголоор **“Монгол шуудан”** хувьцаат компани, товчилсон нэр нь **“Монгол шуудан” ХК**, англиар **“Mongol Post” JSC** болно.

1.7. Компани нь Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт оршино. Утас: (+976)70078918, Факс: (+976) 11-330788, E-mail: [info@mongolpost.mn](mailto:info@mongolpost.mn)

1.8. Компани нь өөрийн тэмдэг, бэлгэдэл (эмблем)-тэй байхаас гадна хууль тогтоомжид заасны дагуу албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэж болно.

1.9. Тэмдэг, бэлгэдлийн загварыг Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөс баталж, Оюуны өмч, улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн компани эдэлнэ.

### **ХОЁР. КОМПАНИЙН ҮНДСЭН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ХУГАЦАА**

2.1 Компанийн үндсэн зорилт нь Монгол Улсын шуудангийн салбарыг хөгжүүлэх, шуудангийн найдвартай ажиллагааг хангах болон Шуудангийн тухай хуулиар хориглоогүй бусад үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх замаар хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж, ашигтай ажиллагааг хангахад оршино.

2.2 Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь дор дурдсан үйл ажиллагаа, тэдгээртэй холбогдон үүсэх бусад ажил, үйлчилгээ байна:

- 2.2.1. Захидал, бичиг, боодол, илгээлт зэрэг шуудангийн бүх нийтийн үйлчилгээ;
- 2.2.2. Захиалгат илгээмжийн худалдаа;
- 2.2.3. Хадгаламж, даатгал, тэтгэвэр, тэтгэмж, цалин хөлс олгох, мөнгөн гуйвуулга хийх зэрэг санхүүгийн үйлчилгээ;

- 2.2.4. Шуудангийн марк, үнэт цаасны эх зураг хийх, хэвлүүлэх, борлуулах;
- 2.2.5. Гадаад дотоодын тогтмол хэвлэлийн захиалга авах, хүргэх, борлуулах;
- 2.2.6. Монгол Улсын Шуудангийн тухай хуулиар зохицуулсан бусад үйлчилгээ, үйл ажиллагаа.
- 2.2.7. Авто машинаар ачаа тээвэрлэх;

2.3 Үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй, орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бизнесийн бусад үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг компанийн ТУЗ гаргана.

2.4 Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний дараа тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

2.5 Компанийг дүрэм болон Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгана.

2.6 Компани нь хязгааргүй хугацаагаар үйл ажиллагаа явуулна.

### **ГУРАВ. КОМПАНИЙН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА**

3.1 Компанийн гаргасан хувьцаа нь нэг бүрийн 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 99,586,363 (ерэн есөн сая таван зуун наян зургаан мянга гурван зуун жаран гурав) ширхэг энгийн хувьцаа байна. Үүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг гагцхүү хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид "ХЭХ" гэх)-аар шийдвэрлэнэ.

3.2 Компанийн зарласан хувьцаа нь нэг бүрийн 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100,000,000 (нэг зуун сая) ширхэг энгийн хувьцаа байна.

3.3 Компани нь энгийн хувьцааг заавал гаргах ба энэ тухай шийдвэрийг ХЭХ-аас гаргана.

3.4 Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу бусад үнэт цаас гаргаж болох ба энэ тухай шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргана.

3.5 Хувьцаа нэмж гаргах замаар компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж болно.

3.6 Компанийн хувьцаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

### **ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ**

4.1 ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэргаргана. Хэрэв ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэр гаргасан бол энэ тухайгаа ТУЗ нь ХЭХ-д тайлагнах үүрэгтэй.

4.2 Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол ТУЗ-ийн энэ тухай шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.

4.3 ТУЗ нь ногдол ашиг хуваарилсан бол түүний тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хурал болон Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнана.

4.4 Компани алдагдалтай ажилласан нөхцөлд ногдол ашиг хуваарилахгүй.

4.5 Компани эргүүлэн авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.

### **ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

5.1 Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааг эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.

5.2 Энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ.

- 5.2.1 ХЭХ зарлах, эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон "бүртгэлийн өдөр" компанийн хувьцааг эзэмшиж

- байсан этгээд хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;
- 5.2.2 ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дараа эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хуульд заасан хугацаанд хувиарлаагүй бол алданги төлөхийг шаардах;
- 5.2.3 Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх;
- 5.2.4 Нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах, энэ эрхээ бусдад бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх;
- 5.2.5 ХЭХ-аар дараах асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах;
- 5.2.5.1 Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх;
- 5.2.5.2 Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх;
- 5.2.5.3 Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах
- 5.2.5.4 Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийнхамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших болсон, эсхүл компанийн төрийн мэдлийн багц хувьцааг худалдсан тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
- 5.2.6 Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч холбогдох журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ-д болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисст нэр дэвшүүлэх;
- 5.2.7 Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэхүдирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах;
- 5.2.8 Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх;
- 5.2.9 Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувийг эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д саналаа хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, ХЭХ зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардан гаргуулах;
- 5.2.10 Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хууль 84 дүгээр зүйлд заасан үүргээ биелүүлээгүй, үүргээ зөрчсөнөөс компанид хохирол



- учруулсан бол уг албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 5.2.11 Хууль тогтоомж болон дүрмээр тогтоосон бусад эрх.
- 5.3 Компанийн хувьцаа эзэмшигч дараах үүрэгтэй:
- 5.3.1 Хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаяг, цахим хаяг, гар утас болон холбоо барих хаягт өөрчлөлт орох тухай бүр үнэт цаасны бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэх;
- 5.3.2 Нийт гаргасан хувьцааны 1/3 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авч эзэмшихийг хүссэн этгээд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу тендер санал зарлах;
- 5.3.3 Нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш ажлын Зоногийн дотор энэ тухай компанид бичгээр мэдэгдэх;
- 5.4. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ.
- 5.5. Компанийн давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хууль болон давуу эрхийн хувьцаа гаргах тухай шийдвэрт заасан нөхцөлд ХЭХ-д саналын эрхтэй оролцоно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх, тэдний хувь нийлүүлэгчдийн хуралдсаналын эрхтэй оролцох нөхцөл зэргийг давуу эрхийн хувьцаа гаргах тухай асуудлыг шийдвэрлэсэн хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрт заасан байна.

### **ЗУРГАА. КОМПАНИЙН УДИРДЛАГА**

- 6.1. Компанийн удирдлага нь дараах бүтэцтэй байна:
- 6.1.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал;
- 6.1.2. Төлөөлөн удирдах зөвлөл;
- 6.1.3. Гүйцэтгэх удирдлага;

### **ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

- 7.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь ХЭХ байна. ХЭХ нь ээлжит, ээлжит бус байна.
- 7.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн ТУЗ санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн (4) сарын дотор зарлан хуралдуулна.
- 7.3. ТУЗ-өөс ХЭХ-ын бүрэн эрхийн хүрээний асуудлыг шийдвэрлүүлэхээр ХЭХ-д хэдийд ч оруулж болно.
- 7.4. Хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах зүйлийг заана:
- 7.4.1. Хурал хуралдуулах газар, өдөр, цаг;
- 7.4.2. Хурлын хэлэлцэх асуудал;
- 7.4.3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
- 7.4.4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам;
- 7.4.5. Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт;
- 7.4.6. Саналын хуудсаар санал авах бол тухайн саналын хуудасны агуулга;
- 7.4.7. Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;
- 7.4.8. Хурлын дарга;
- 7.4.9. Тооллогын комиссын дарга, гишүүд.

- 7.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна.
- 7.6. Компани хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор хурлын зарыг "Хувьцаат компанийн ХЭХ-ын зар хүргэх журам"-ын дагуу нийтэд мэдээлнэ. Хурлын зарыг ийнхүү нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлнэ.
- 7.7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэр гаргасан бол хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 30 хоногийн дараа, санал шаардлагад үндэслэн хуралдуулах шийдвэр гаргасан бол ийнхүү санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш холбогдох журамд нийцүүлэн 45 хоногийн дотор тухайн хурлыг хуралдуулна. Хойшлогдсон хурлыг ажлын 20 хоногийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас 10-аас доошгүй хоногийн өмнө хурлын зарыг "Хувьцаат компанийн ХЭХ-ын зар хүргэх журам"-ын дагуу нийтэд мэдээлнэ.
- 7.8. Хурлын зард дараах зүйлийг тусгана:
- 7.8.1. Компанийн оноосон нэр, байршил;
  - 7.8.2. Хурал хийх өдөр, цаг, газар;
  - 7.8.3. Бүртгэлийн өдөр;
  - 7.8.4. Хурлаар хэлэлцэх асуудал, шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам.
- 7.9. Ээлжит хурал хуралдах үед хувьцаа эзэмшигчид дараах мэдээллийг танилцуулна:
- 7.9.1. Санхүүгийн жилийн тайлан;
  - 7.9.2. Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
  - 7.9.3. Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлүүд;
  - 7.9.4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшсэн хүний тухай танилцуулга, дүгнэлт;
  - 7.9.5. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо;
  - 7.9.6. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин урамшуулал;
  - 7.9.7. Бизнесийн үйл ажиллагааны тайлан.
- 7.10. Ээлжит бус хурлыг дараах тохиолдолд ТУЗ хуралдуулна:
- 7.10.1. ТУЗ-ийн нийт гишүүдийн талаас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
  - 7.10.2. ТУЗ-ийн 2 буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрхтэй хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан;
  - 7.10.3. Компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;
  - 7.10.4. Компанийн өр нь өөрийн хөрөнгөөс хоёр жил дараалан илүү болж, хасах утгатай болсон;
  - 7.10.5. ТУЗ шийдвэр гаргасан;
  - 7.10.6. Аудитын хорооноос ээлжит бус хурал хийхийг шаардсан.
- 7.11. Дараах асуудлыг компанийн ХЭХ-аар хэлэлцэж шийдвэрлэнэ:
- 7.11.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах;
  - 7.11.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон тусгаарлах хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;
  - 7.11.3. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
  - 7.11.4. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

- 7.11.5. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
  - 7.11.6. Хувьцааг хуваах, нэгтгэх;
  - 7.11.7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох, тэдний цалин, урамшууллын хэмжээг тогтоох бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар ТУЗ-ийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгон, орлох хүнийг сонгож болно;
  - 7.11.8. Хувьцаа эзэмшигчид нь хувьцаа, бусад үнэт цаасыг хууль тогтоомжид заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлэх эсэх;
  - 7.11.9. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  - 7.11.10. ТУЗ-ийн ирүүлсэн саналыг үндэслэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
  - 7.11.11. Компанийн тухай хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;
  - 7.11.12. Компанийн тухай хуулийн 96.4-т заасан тайлан;
  - 7.11.13. Компанийн тухай хууль болон ТУЗ-ийн шийдвэрээр ХЭХ-аар шийдвэрлүүлэхээр оруулсан бусад асуудлууд;
- 7.12. Хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо зөвхөн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшүүлсэн этгээдийн хүрээнд хэлэлцэн шийдвэр гаргана. Хэрэв нэр дэвшүүлсэн этгээдийг шаардлага хангахгүй гэж үзвэл дахин нэр дэвшүүлэх тухай шийдвэр гаргана.
- 7.13. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ХЭХ-д оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.
- 7.14. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн асуудлаар тогтоол, хурлын тэмдэглэл гаргана. Хурлын тэмдэглэлд хурлын дарга гарын үсэг зурна.

### **НАЙМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

- 8.1. ХЭХ-ын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. ТУЗ-ийн гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас 2 жилийн хугацаатайгаар сонгож, чөлөөлнө.
- 8.2. ТУЗ нь 9 (ес) гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 (гурав) нь хараат бус гишүүн байна.
- 8.3. ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 8.3.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлогыг тодорхойлох;
  - 8.3.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
  - 8.3.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан зорилтот түвшинд үндэслэн компанийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлах;
  - 8.3.4. Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, удирдлагын зардлын дээд хязгаарыг батлах,
  - 8.3.5. Компанийн зарласан хувьцааны тоо, хэмжээнд багтаан хувьцаа гаргах асуудлыг шийдвэрлэх;
  - 8.3.6. Компанийн энгийн хувьцаа болон бусад үнэт цаас гаргах;
  - 8.3.7. Компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
  - 8.3.8. Компанийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах, эргүүлэн авах шийдвэр гаргах;
  - 8.3.9. Компанийн Гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;

- 8.3.10. Компанийн Гүйцэтгэх захиралтай байгуулах Хөлсөөр ажиллах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах шийдвэр гаргах;
  - 8.3.11. Компанийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох, компанийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;
  - 8.3.12. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;
  - 8.3.13. Компаниас хуваарилах ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журам, хугацааг тодорхойлох;
  - 8.3.14. ТУЗ, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
  - 8.3.15. Гадаадад болон аймаг, нийслэлийн төвд компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах”
  - 8.3.16. Хууль тогтоомжийн дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
  - 8.3.17. ХЭХ-ын бүрэн эрхэд хамаарахгүй бусад асуудлыг шийдвэрлэх;
- 8.4. ТУЗ хурал нийт гишүүдийн дийлэнх олонхи нь оролцсоноор хүчин төгөлдөр болно.
- 8.5. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.
- 8.6. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүргийг хүлээнэ. Хурлын тэмдэглэлд хуралд оролцсон бүх гишүүд өөрсдийн хэлсэн үг, гаргасан саналын үнэн зөвийг хянан гарын үсэг зурна.
- 8.7. ТУЗ-өөс гаргасан тогтоолыг ТУЗ танилцаж, баталгаажуулсны үндсэн дээр ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдгийг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 8.8. ТУЗ-ийн даргыг түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргаас, эсхүл ТУЗ-өөс томилсон гишүүн гүйцэтгэнэ.
- 8.9. ТУЗ-ийн ээлжит хурлыг улиралд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдаан хийж болно.
- 8.10. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.
- 8.11. ТУЗ-ийн хурлыг зарлах, хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүдийн хуралд оролцох, асуудлыг хэлэлцэх, хурлын дэгийг тогтоох, ТУЗ-ийн даргын эрх болон бусад холбогдох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна. Энэхүү журмыг ТУЗ батална.
- 8.12. Хараат бус гишүүн нь дараах шаардлагыг хангасан этгээд байна:
- 8.12.1. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй;
  - 8.12.2. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;
  - 8.12.3. Төрийн үйлчилгээнээс бусад төрийн алба хашдаггүй;
  - 8.12.4. Компанитай ТУЗ-ийн гишүүнээс бусад байдлаар бизнесийн материаллаг холбоогүй.
- 8.13. Хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүрэгтэй:

- 8.13.1. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэласуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;
  - 8.13.2. Компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
  - 8.13.3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх;
  - 8.13.4. Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт хийх талаар санал боловсруулах;
  - 8.13.5. Гүйцэтгэх удирдлагын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг үр ашигтай зохион байгуулахад хяналт тавих.
- 8.14. Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудитын, Цалин, урамшууллын, Нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна. Хороодын дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус мөн хараат бус гишүүн байна;
- 8.15. Аудитын хорооны 2/3 нь хараат бус гишүүн байна.
- 8.16. Хороо нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж, ТУЗ-ийн хуралд танилцуулан шийдвэр гаргуулах үүрэгтэй.
- 8.17. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:
- 8.17.1. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
  - 8.17.2. Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтнуудыг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах, ТУЗ-д танилцуулах;
  - 8.17.3. Аудитын байгууллагыг сонгох, тэдний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах, хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн аудитын байгууллагад чиглэл өгөх (чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар аудитын байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ);
  - 8.17.4. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
  - 8.17.5. Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;
  - 8.17.6. Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.
- 8.18. Нэр дэвшүүлэх хороо нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:
- 8.18.1. ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

- 8.18.2. ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүдийн хувьд энэхүү дүрмийн 8.13-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 8.18.3. ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, ХЭХ-д шууд нэр дэвшүүлэх;
- 8.18.4. ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 8.18.5. Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;
- 8.18.6. ТУЗ-ийн гишүүдээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
- 8.18.7. Бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд аливаа хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүн байх эрхгүй этгээдийн нэрийг дэвшүүлэхээс татгалзах;
- 8.18.8. Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;
- 8.18.9. Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй.
- 8.19 Цалин урамшууллын хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
  - 8.19.1 ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
  - 8.19.2 ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
  - 8.19.3 Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;
  - 8.19.4 Компанийн стратеги төлөвлөгөөг судалгааны үндсэн дээр боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж батлуулах, хэрэгжилтэнд хяналт тавих, дүгнэлт гаргах;
  - 8.19.5 Санхүүгийн тайлан, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн стратеги төлөвлөлтөнд нийцсэн эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах, шинээр хийгдэх их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд стратегийн эрсдлийн урьдчилан дүгнэлт гаргах, чиглэл, зөвлөмж боловсруулах;
  - 8.19.6 Компанийн үнэ цэнийг тодорхойлж, хувьцааны үнэ цэнийг дээшлүүлэх, хамгаалахад чиглэсэн бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтэнд хяналт тавих, дүгнэлт гаргах;
  - 8.19.7 Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.
- 8.19. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно.
- 8.20. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллах этгээд нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.
- 8.21. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасны дагуу ажиллах бөгөөд шаардлагатай бол нэмэлт үүргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгаж болно.

8.22. ТУЗ нь жилд нэгээс доошгүй удаа ХЭХ-д ажлаа тайлагнана.

### **ЕС. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА**

9.1. Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх удирдлага нь хувь хүн байх бөгөөд уг этгээд компанийн Гүйцэтгэх захирал байна.

9.2. Гүйцэтгэх захирлыг сонгох, томилох, өөрчлөх асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.

9.3. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд ТУЗ-ийг төлөөлж түүний дарга гарын үсэг зурна. Гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна;

9.4. Гүйцэтгэх захирал нь өөрт олгосон эрхийн хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

9.5. Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг ТУЗ хэдийд ч гаргаж болно.

9.6. Гүйцэтгэх захирал нь компанийн Дэд захирал, Төлөвлөлт санхүү бүртгэлийн хэлтсийн дарга /ерөнхий нягтлан бодогч/-ыг томилох, чөлөөлөх тухай асуудлыг ТУЗ-тэй зөвшилцөнө.

9.7. Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна.

9.7.1. Менежментийн ур чадвартай, 3-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажил гүйцэтгэж байсан, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, удирдлагын зохих дадлага туршлагатай, удирдлагын ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг, дээд боловсрол эзэмшсэн байх;

9.7.2. Зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

9.7.3. Ял шийтгэлгүй байх;

9.7.4. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх.

9.8. Өдөр тутмын болон шуурхай үйл ажиллагааны талаар Гүйцэтгэх захиралд зөвлөх эрх бүхий Захирлын зөвлөл ажиллана. Захирлын зөвлөлийн ажиллах журмыг Гүйцэтгэх захирал батална.

9.9. Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай холбогдож үүссэн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх тохиолдолд ТУЗ-өөс томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгч компанийг төлөөлөн оролцоно.

9.10. Гүйцэтгэх захирал дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ.

9.10.1. ТУЗ-ийн өмнө компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жилд хоёроос доошгүй удаа ажлын үр дүн, гэрээний үүргийн биелэлтийг тайлагнан дүгнүүлэх;

9.10.2. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг хуульд заасан хугацаанд гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг хариуцах;

9.10.3. Компанийн үйл ажиллагааны тухайн жилийн зорилтот түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, ТУЗ-д танилцуулан батлуулах;

9.10.4. Дүрэм болон холбогдох хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, стандарт, норм норматив,

- компанийн ХЭХ-ын болон ТУЗ-ийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;
- 9.10.5. Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;
- 9.10.6. Компанийн эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан компанийг удирдах;
- 9.10.7. Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийн нууцлалыг хадгалах, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх;
- 9.10.8. Салбар төлөөлөгчийн газрын удирдлагыг ТУЗ-тэй зөвшилцснөөр томилж, чөлөөлөх, тэдэнтэй компанийг төлөөлөн хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээ байгуулах;
- 9.10.9. ТУЗ-өөс баталсан орон тооны дээд хязгаар, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд компанийн ажлын байрны жагсаалт, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох;
- 9.10.10. Компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг ТУЗ-ийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;
- 9.10.11. Компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;
- 9.10.12. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах;
- 9.10.13. ТУЗ-ийн зөвшөөрлийн дагуу зарим эрх, үүргээ итгэмжлэлийн үндсэн дээр компанийн холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 9.10.14. Гүйцэтгэх захирал нь компанийн ТУЗ-ийн гишүүн байж болно.
- 9.10.15. Хуульд заасан бусад.

### **АРАВ. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН**

10.1. Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, Гүйцэтгэх захирал, дэд захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн /Дүрмийн 9.8 дахь хэсэгт заасан Захирлын зөвлөлийн гишүүдийг ойлгоно/, ерөнхий нягтлан бодогч, Санхүү эрхэлсэн нэгжийн удирдлага, дотоод хяналтын нэгжийн удирдлага, худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн удирдлага, аймаг хариуцсан шуудангийн үйлчилгээний нэгжийн удирдлагыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно,

10.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хууль, дүрэм, ТУЗ-ийн баталсан дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

10.3. Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага, түүний хэмжээг тогтоох асуудлыг ТУЗ-тэй байгуулсан гэрээ, компанийн хөдөлмөрийн дотоод журмаар тогтоох бөгөөд тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

10.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд зааснаар үүрэг, хариуцлага хүлээнэ.



## **АРВАН НЭГ. КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО**

11.1. Компанийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:

- 11.1.1. Хувьцаа эзэмшигчдийн хяналт;
- 11.1.2. Дотоод хяналт;
- 11.1.3. Хөндлөнгийн аудит.

11.2. Хувьцаа эзэмшигчдийн хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо хэрэгжүүлнэ.

11.3. Аудитын хороо нь компанийн дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган, үйл ажиллагаагаа ХЭХ-д тайлагнана.

11.4. Аудитын хороо нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгахдаа дүрэм болон холбогдох хуулиар олгогдсон эрхийг эдэлнэ.

11.5. Аудитын хороо нь дотоод аудитын нэгжийн захирлыг томилж, төсвийг батлаж өгнө.

11.6. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Гүйцэтгэх захиралд томилсон дотоод хяналтын нэгж хэрэгжүүлнэ.

11.7. Дотоод хяналтын нэгж нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ-тэй зөвшилцөн Гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

11.8. Дотоод хяналтын нэгж компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавьж, гүйцэтгэл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, дүрэм, ХЭХ-ын тогтоолд нийцэж байгаа эсэхийг хангаж ажиллана.

11.9. Дотоод хяналтын алба ньшалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжийг гүйцэтгэх удирдлагад өгөх, ТУЗ-д танилцуулах, мэдээлэх үүрэгтэй.

11.10. Компанийн хөндлөнгийн аудитыг ТУЗ-өөс сонгосон тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаар хийлгэнэ.

11.11. Хөндлөнгийн аудитын тайланг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт гаргана.

## **АРВАН ХОЁР. ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ**

12.1. Их хэмжээний хэлцэл гэж тухайн хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 87, 88 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

12.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж эрх бүхий албан тушаалтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн компанитай хийж байгаа аливаа хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 89, 91, 92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

12.3. Компани нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн энэхүү дүрмийн 12.2-т заасан хэлцэл, түүний үнэ зэргийг улирал, жилийн тайлангийн тодруулгад тусгах замаар нийтэд мэдээлэх үүрэгтэй.

## **АРВАН ГУРАВ. КОМПАНИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАЙЛАН**

13.1. Компани нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан Хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компанийн Гүйцэтгэх захирал хариуцна.

13.2. Компанийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогч байх бөгөөд түүнийг ТУЗ-ийн зөвшөөрөлтэйгээр Гүйцэтгэх захирал томилж, чөлөөлнө.

13.3. Компани нь хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргуулсны дараа холбогдох хууль тогтоомжид заасны дагуу жилийн санхүүгийн тайлан, ашиг ба алдагдлын тайлангаа компанийн Хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудад танилцуулна.

13.4. Компанийн санхүүгийн жилийн эхлэх хугацаа тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдөр, дуусах хугацаа мөн оны 12 дугаар сарын 31-ний өдөр байна.

## **АРВАН ДӨРӨВ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

14.1. Компани Нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан журмын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргана.

14.2. Компанийн санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:

- 14.2.1. Баланс;
- 14.2.2. Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;
- 14.2.3. Мөнгөн гүйлгээний тайлан;
- 14.2.4. Өмчийн өөрчлөлтийн тайлан;
- 14.2.5. Хуримтлагдсан ашгийн тайлан;
- 14.2.6. Нэмэлт тайлбар, тодруулга;
- 14.2.7. Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр, төрөл, үнийн дүнгийн хамт;
- 14.2.8. Эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин, урамшууллын дүн, албан тушаалтан бүрийн нэрээр гаргах;
- 14.2.9. Хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон бусад мэдээлэл.

14.3. Санхүүгийн тайланг компанийн ТУЗ-ийн зөвшөөрлөөр томилогдсон хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулах бөгөөд ТУЗ санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган, ХЭХ-д оруулж, хэлэлцүүлнэ.

## **АРВАН ТАВ. КОМПАНИЙН БИЧИГ БАРИМТЫГ ХАДГАЛАХ**

15.1. Компани нь дараах бичиг баримтыг хадгалах үүрэгтэй:

- 15.1.1. Компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга, компанийн бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, лиценз;
- 15.1.2. ХЭХ, ТУЗ, Гүйцэтгэх захирлын баталсан компанийн дотоод баримт бичиг;
- 15.1.3. Компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай шийдвэр, ажиллах журам,
- 15.1.4. Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг;

- 15.1.5 ХЭХ, ТУЗ болон Гүйцэтгэх захирлын зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, компанийн Гүйцэтгэх захирлын тушаал, байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчил, бусад гэрээ, хэлцэл түүний биелэлттэй холбогдох баримт бичиг;
  - 15.1.6 Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, хөлсөөр ажиллах болон хөдөлмөрийн гэрээ;
  - 15.1.7 Аудитын дүгнэлт;
  - 15.1.8 Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;
  - 15.1.9 Хувьцаа болон үнэт цаас гаргах журам;
  - 15.1.10 Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн бичиг баримт;
  - 15.1.11 Эрх бүхий албан тушаалтан болон нийт ажилчдад олгосон цалин, шагнал, урамшуулалтай холбоотой бичиг баримт;
  - 15.1.12 Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нэрсийн жагсаалт болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо;
  - 15.1.13 Бусад баримт бичгүүд.
- 15.2. Компани нь баримт бичгийг өөрийн үйл ажиллагаа эрхлэн явуулах газарт хадгална.
- 15.3. Компани нь өөрийн дүрэм, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг байнга хадгална. Бусад баримт бичгийг 5 жилийн хугацаатайгаар хадгалах бөгөөд хугацаа дууссаны дараа архивт шилжүүлнэ.
- 15.4. ХЭХ, ТУЗ, компанийн хувьцаа болон үнэт цаас гаргах, эргүүлэн худалдан авах, компанийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгатай холбогдол бүхий баримт бичгийг хүлээн авах, хадгалах, танилцуулах, архивт шилжүүлэх ажиллагааг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эрхлэн гүйцэтгэнэ. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг биечлэн хариуцна.
- 15.5. Компанийн талаарх мэдээлэл, компанийн нэгдмэл сонирхолтой этгээд түүнтэй холбогдох мэдээлэл авах асуудлыг Компанийн тухай хуулийн 98, 99 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

### **АРВАН ЗУРГАА. КОМПАНИЙГ ТАТАН БУУЛГАХ**

- 16.1. Компанийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буулгана.
- 16.2. Татан буулгах комисс томилогдсоноор компанийн Гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.

### **АРВАН ДОЛОО. БУСАД**

- 17.1. Энэ дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 17.2. Дүрэм болон түүнд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлсэнээр хүчин төгөлдөр болох бөгөөд үндсэн эхийг компани дээр хадгална.
- 17.3. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт, өөрчлөлт нь энэ дүрмийн 17.2-т заасан байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн уг дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

.....оОо.....



## **“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

**2024 оны 04 сарын 29 өдөр**

**Дугаар \_\_\_**

**Улаанбаатар хот**

*Төсөл*

**Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны зардлын төсөв батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг хавсралтын дагуу нийт 234,000,000.00 (Хоёр зуун гучин дөрвөн сая) төгрөгөөр баталсугай.

2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороонд даалгасугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**Д.БАЛЖИННЯМ**

*“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн  
ээлжит хурлын ..... оны .... сарын .... өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт*

**“Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны зардлын төсөв**

№	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал /мян.төг/	Сар	Нийт /мян.төг/
<b>1. Цалингийн зардал</b>					
1	ТУЗ-ийн дарга	1	1,500.0	12	18,000.0
2	Хорооны дарга	3	1,400.0	12	50,400.0
3	Гишүүд	5	1,300.0	12	78,000.0
4	Н/б-ийн дарга	1	1,300.0	12	15,600.0
5	НДШ /12%			12	19,500.0
<b>Дүн</b>					<b>181,500.0</b>
<b>2. Бичиг хэрэг, хангамж болон бусад зардал</b>					
7	Бичиг хэрэг, хангамжийн зардал				2,500.0
8	Шатахууны зардал				10,000.0
9	Томилолтын зардал				40,000.0
<b>Дүн</b>					<b>52,500.0</b>
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>					<b>234,000.0</b>

## ТЭМДЭГЛЭЛ





“Монгол шуудан” ХК, Сүхбаатарын талбай-1  
ЧД-ийн 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө  
УЛААНБААТАР 15160, МОНГОЛ УЛС

Утас: +(976) 1800-1613, Факс: +(976) 11-330788,  
И-Мэйл: [info@mongolpost.mn](mailto:info@mongolpost.mn)

Шуудангийн хаяг:  
“Монгол шуудан” ХК  
Шуудангийн хайрцаг-1106  
УЛААНБААТАР 15160